

Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбарт хэрэгжүүлсэн болон хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээний мэдээлэл

1)“Харилцаа холбооны сүлжээ хүрээгүй алслагдсан багт үүрэн холбооны үйлчилгээ хүргэх 40 цэг” төслийг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулсан бөгөөд уг төслийн хүрээнд Архангай, Булган, Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Дундговь, Төв, Завхан, Увс аймгийн алслагдсан 25 багт үүрэн холбооны үйлчилгээг хүргэх гэрээг Мобиком Корпораци ХХК болон Скайтел ХХК-тай байгуулж, гэрээт ажлыг эхлүүлж, 2025 оны байдлаар 16 байршлуудад үүрэн холбооны сүлжээг асаагаад байна. 2026 онд үдсэн 9 байршилд үүрэн холбооны сүлжээг асаана. Гэрээний нийт дүн /сая.төг/: 5,021.00₮ (он дамжин санхүүжнэ.)

2)“Үүрэн холбооны үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор эрчим хүчний саатал ихтэй алслагдсан багт байрших бааз станцын нөөц тэжээлийн эх үүсвэрийг шинэчлэх (10 сайт)” төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулсан бөгөөд төслөөр нийлүүлсэн генератор, батарей, хамгаалалтын торон хашааг Өмнөговь, Дундговь, Дорнод, Баянхонгор, Завхан, Архангай, Сүхбаатар, Булган аймгийн нийт 10 байршилд суурилуулж, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК -д ашиглалтад хүлээлгэн өгсөн. Төслийн үр дүнд бүх нийтийн үүрэгт үйлчилгээ дууссан алслагдсан сайтуудын цахилгаан, эрчим хүчний асуудлыг шийдвэрлэж, үүрэн холбооны үйлчилгээг тухайн бүс нутагт үргэлжлүүлэн хүргэж байна. Гэрээний дүн /сая.төг/: 532,80₮

3)“Алслагдсан орон нутаг, сумын шуудангийн үйлчилгээний чанарыг сайжруулах, шуудангийн хяналт, бүртгэл, байршлын мэдээллээр хангах технологийн шийдэл, тоног төхөөрөмж нэвтрүүлэх төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулсан бөгөөд төслөөр 182 суманд шуудангийн үйлчилгээний найдвартай байдлыг хангах тоног төхөөрөмжийг нийлүүлснийг “Монгол шуудан” ХК-д хүлээлгэн өгч, үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлээд байна. Гэрээний дүн /сая.төг/: 166.53₮

4)“Харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг алслагдсан бүс нутагт турших, нэвтрүүлэхэд шаардлагатай нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмж (30 цэг)” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан бөгөөд төслөөр нийлүүлсэн нам орбитын хиймэл дагуулын төхөөрөмжийг Төв, Хэнтий, Говь-Алтай аймгийн Засаг даргын тамгын газар тус бүрд актаар хүлээлгэн өгч, хөрөнгийг тухайн аймагт шилжүүлсэн. Төслийн үр дүнд тухайн аймгийн шилэн кабельд холбогдоогүй төрийн байгууллагууд өндөр хурдны интернэтэд холбогдсон. Гэрээний дүн /сая.төг/: 77.55₮

5)“Харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ хүрээгүй хүн ам, газар нутгийн талаарх зах зээлийн нөхцөл байдлын судалгааг хийлгэх” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан бөгөөд үйлчилгээний ажилд холбогдох судалгааны тайлан, баримт материалыг төслийн гүйцэтгэгчээс

хүлээж авсан. Уг судалгааг цаашдын сүлжээ, үйлчилгээг төлөвлөхөд ашиглан ажиллаж байна. Гэрээний дүн /сая.төг/: 79.30₮

б)“Сангийн хөрөнгөөр сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан бөгөөд үйлчилгээний ажилд холбогдох судалгааны тайлан, баримт материалыг төслийн гүйцэтгэгчээс хүлээж авсан. Төслийн үр дүнд үүргийн сангаас хэрэгжүүлсэн төслүүдийн шууд бус үр өгөөж маш өндөр байгааг, үүргийн сангаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүд тодорхой үр дүнд хүүрч байгааг тогтоосон. Уг судалгааг цаашдын сүлжээ, үйлчилгээг төлөвлөхөд ашиглан ажиллаж байна. Гэрээний дүн /сая.төг/: 97.80₮

-----oOo-----